

## НИЙГЭМ СУДЛАЛ 10-Р АНГИ \А ХУВИЛБАР \

1. Хүмүүс хэрэгцээгээ хангах, зөрчил маргаан, эмх замбараагүй байдалд хүргэхгүйн тулд үүргээ хуваарилан зохион байгуулалтад орж, хянаж, зохицуулах замаар амьдарч буй хамтын амьдралын хэлбэрийг юу гэх вэ?  
А. Нийгэм В. Улс С. Үндэстэн D. Төр
2. Нийгмийн хэсэг, элементүүдийн хооронд бэхжсэн тогтвортой харилцаа холбоог юу гэх вэ?  
А. Нийгмийн институт В. Нийгмийн элемент С. Нийгмийн бүтэц  
D. Нийгмийн статус
3. Хоёр ба түүнээс дээш тооны хүмүүс харилцан бие биенийхээ үйлдэлд бэлгэ тэмдгийг ашиглах замаар хариу өгч буй үйл явцыг юу гэх вэ?  
А. Нийгмийн харилцаа В. Харилцан үйлдэл С.Бэлгэ тэмдэгтийн үйлдэл  
D. Нийгмийн үйлдэл
4. Нийгмийн бүтэц гэдэг нь нийгмийн хэсэг, элементүүдийн хооронд бэхжсэн тогтвортой харилцаа холбоог хэлнэ” гэж хэн хэлсэн бэ?  
А. Э.Дюркгейм В. К.Маркс С. Ж.Г.Мид D. Занден
5. Соёл судлал нь хэддүгээр зууны үед бие даасан шинжлэх ухаан болон бүрэлдэн тогтсон бэ?  
А.ХІХ зууны эхэн үед В.ХХ зууны эхэн үед С.ХХІ зууны эхэн үед D.ХVІІІ зууны эхэн үед
6. Монголын соёлын нэгдмэл шинжид аль нь хамаарахгүй вэ?  
А. Монгол аж төрөх ёс, ардын урлаг, хэл, төрт ёс, аман болон бичгийн соёл, хуримтлуулсан мэдлэг туршлага, ёс заншил В. “Би монгол хүн” хэмээн бахархах  
С. Могол, Казак, үндэсний соёлоос бүрддэг D. Бүгд хамаарна
7. Үндэсний соёл дэд соёлуудаас бүрддэг. Аль нь дэд соёл биш вэ?  
А. Үндэс угсаа В. Ардын С. Хот хөдөөгийн D. Ажил мэргэжлийн
8. Хүн бол бэлгэдлийн амьтан” бэлгэдлийн онолын үндэслэсэн эрдэмтэн хэн бэ?  
А. Ж. Мердок В. К.Клакон С. Э.Кассирер D. Э. Тайлор
9. Монгол улсын Үндсэн хуулинд заасан иргэний үндсэн үүргийг нэрлэхдээ илүүц зүйл оруулсан бол аль нь вэ?  
А.Татвар төлөх В.Эх орноо хамгаалах, эр цэргийн алба хаах С.Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх D.Байгаль орчноо хамгаалах
10. “Magna charta” буюу “Эрх чөлөөний харти” хэмээх баримт бичигт ямар зарчмыг анхлан тунхагласан байдаг вэ?  
А.Боолуудыг чөлөөлж, бүх хүмүүс ижил эрхтэй гэдгийг тунхагласан зарчим  
В.Шүүхийн шийдвэргүйгээр улсын хуулиас гадуур хүнийг гэм буруутайд тооцож үл болох зарчим  
С.Хүн бүр тэгш боломжоор хангагдах зарчим  
D.Жендерийн тэгш байдлыг хангах зарчим
11. Хүний эрхийн түгээмэл тунхаглалд хүний эрхийн суурь зарчмуудаас илүүцийг ол  
А. Тэгш байдлыг хангах В.Хэм хэмжээг хангах С.Ялгаварлан гадуурхахгүй байх  
D.Түгээмэл салшгүй байх
12. Боловсрол эзэмших эрхийн төлөө тэмцэгч Малала Юсуфзай хэдэн сая хүүхэд боловсрол эзэмшиж чадахгүй байна гэж хэлсэн бэ?  
А. 62сая В. 60 сая С. 61 сая D. 63 сая
13. “ Эрх чөлөөний харти “ хэмээх баримт бичгийг хаана анхлан гаргасан бэ?  
А. Англи В. Франц С. Ром D. Грек
14. Сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсон этгээдийг эрх зүйн ямар чадамжтай вэ?  
А. Бүрэн чадамжтай В. Бүрэн бус чадамжтай С.Заримдаг чадамжтай  
D. Чадамжгүй
15. Тухайн улсын хэмжээгээр нэг жилийн хугацаанд үйлдвэрлэсэн, эцсийн бараа, үйлчилгээний зах зээлийн үнийн дүнг .....гэнэ.

- А.Дотоодын нийт бүтээгдэхүүн      В.Үндэсний нийт бүтээгдэхүүн      С.Нэрлэсэн  
Дотоодын нийт бүтээгдэхүүн      D.Үндэсний цэвэр орлого
16. ДНБ-ны тодорхойлолтод хамаарах өгөгдлийг олно уу?  
А.Эцсийн бараа, үйлчилгээний өртөг байх  
В.Нэг жилийн хугацаанд үйлдвэрлэсэн байх  
С.Тухайн улсын хэмжээгээр буюу газар нутаг дээр үйлдвэрлэсэн байх  
D. Дээрх бүгд зөв
17. Ажилгүйдэл 1.0% өсөхөд үйлдвэрлэлийн хэмжээ 2.5% буурдаг болохыг Английнэрдэмтэн баталжээ. Энэхүү ажилгүйдэл ба ДНБ-ний хоорондох хамаарлыг.....гэнэ.  
А.Лафферийн муруй      В.Оукены хууль      С.Госсений муруй  
D.Лоренцийн муруй
18. Төрийн орлого нь  
А. Цалин      В. Зээлийн хүү      С. Түрээсийн төлбөр      D. Шууд бус татвар
19. Ихэнхдээ хувийн шалтгаанаар үүсдэг ажилгүйдэл бол...  
А. Шилжилтийн      В. Улирлын      С. Бүтцийн      D. Мөчлөгийн
20. ХХ зууны эхээр гүйлгээнд байгаа мөнгөний тоо хэмжээ нь бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн түвшинд нөлөөлдөг болохыг судлан гүйлгээнд байгаа мөнгөний хэмжээ хэдий их байна, бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ төдий чинээ өндөр болдгийг тогтоосон эдийн засагч хэн бэ?  
А. А.Смит      В. Д.Рикардо      С. Ж.Кейнс      D. Фишер
21. “Ардчилал нь ард түмнээс сонгогдсон, ард түмний төлөө, ард түмний өөрсдийнх нь засаглал юм” гэж хэн хэлсэн бэ?  
А. У.Черчилль      В. Т.Жефферсон      С. К.Поппер      D. А.Линкольн
22. Монгол улсын “Шинэ үндсэн хууль” хэдэн онд батлагдсан бэ?  
А. 1992.01.13      В.1940.06.30      С. 1960.11.30      D. 1924.11.26
23. Цэгийн оронд тохирох өгөгдлийг бичнэ үү? .....нь иргэд улс төрийн шийдвэр гаргах, хууль боловсруулах үүрэг бүхий албан тушаалтаныг сонгож, түүгээр дамжуулан засаглалыг хэрэгжүүлэх хэлбэр юм.  
А. Сонгодог ардчилал      В.Шууд ардчилал      С.Төлөөллийн ардчилал  
D.Оролцооны ардчилал
24. Төр нь хүний эрхийг хамгаалах үүрэгтэй тул иргэдэд төрийн бүх үйл ажиллагааг нээлттэй байхыг шаарддаг. Ардчилсан нийгэмд төрийн үйл ажиллагаа нээлттэй байснаар иргэдийн зүгээс улс төрчид, төрийн албан хаагчдад хяналт тавих, тэдний үйл ажиллагааг сайжруулах, авлига, хээл хахуульд өртөхөөс урьдчилан сэргийлэх орчныг бүрдүүлэх нь ардчиллын ямар зарчим бэ?  
А. Зөвшилцлийн зарчим      В. Хууль дээдлэх зарчим      С. Шударга байх зарчим      D. Нээлттэй зарчим
25. Эрх зүйт төрийн төлөө” “Ардчилал бидний зорилт” “Хүнд суртлын аппаратыг устая” “Хүний эрхийг дээдлэе” гэх мэт уриа лоозон хэдэн оны хувьсгалд гарсан бэ?  
А. 1911 он      В. 1921 он      С. 1990 он      D. Аль нь ч биш
26. Ардчиллын үнэт зүйлсийг нарийвчлан судалж, ойлголтыг цэгцэлсэн ба плюралист онолын төлөөлөгч хэн бэ?  
А. А. Смит      В. Р. Даль      С. Ж.Локк      D. У.Ростоу
27. Монгол цэргийн чадвар цэнхэр дуулгатнуудад үлгэр жишээ болж байна гэж хэн хэлсэн бэ?  
А. Дэвид Шийрэр      В. И.Бентам      С. Бан Гим Мун      D. Кофи Аннан
28. Дэлхийн улс ба улс бус оролцогчид хоорондын олон талт харилцаа, тэдний гадаад бодлого, үйл ажиллагааг судалдаг нийгмийн шинжлэх ухааны салбарыг юу гэдэг вэ?  
А. Дипломат ухаан      В. Олон улсын харилцаа      С. Гадаад бодлогын харилцаа  
D. Олон улсын эрх зүйн харилцаа
29. Монгол улс гадаад бодлогынхоо хүрээнд нутаг дэвсгэрээ цөмийн зэвсэггүй бүс болгон зарласан оныг олж тэмдэглэ.  
А. 2000 он      В. 1916 он      С. 1996 он      D. 1992 он

30. Монгол улс хоёр хөрштэйгээ харилцах харилцааны чиглэлүүдийг нэрлэхдээ илүүц зүйл оруулсан бол аль нь вэ?

А.Хамтын ажиллагааны В. Эдийн засгийн С. Соёлын Д.Боловсролын

31. Зөв хариултыг сонгоно уу.

1	Нийгмийн харилцан үйдлийн явцад хувь хүн бусдын үүргийг хүлээн авах замаар өөрийн “БИ нь бүрэлдэн бий болдог”	A	К. Маркс
2	“Өөрийнхөө санаа бодлыг илэрхийлэхдээ хэрэглэж буй бэлгэ тэмдэг , худалдаа арилжаандаа хэрэглэж буй мөнгөний тогтолцоо, мэргэжлийн зүгээс дагаж мөрдөх горим журам гэх мэт зүйлс надаас , миний хэрэглээнээс үл хамааран оршдог”	B	Ж. Мид
3	“ Хүмүүс өөрсдийнхөө түүхийг бүтээж байдаг, яаж бодсоноороо бус , өөрсдөө сонгоогүй бөгөөд байж байсан, тэдэнд өгөгдсөн , өнгөрсөн үеэс дамжиж ирсэн нөхцөлд бүтээж байдаг”	C	Э. Дюркгейм
4	Нийгмийн институтын чиг үүргийг\ функц\ судална гэлэг нь түүний гүйцэтгэж буй үүрэг буюу үйлдлийн үр дүнд ямар үр дагавар бий болов гэдгийг судлахыг хэлнэ”	D	Р.Мертон

A.1C,2B,3A,4D В. 1B,2C,3A,4D С. 1A, 2C, 3B, 4C D. 1B, 2A, 3C, 4D

32. Аль ч ард түмний түүх, соёл, угсаатны зүйд хөдөлмөрийн зэвсэг бүтээх, биеэ гоёх, цус холилдохыг хориглох, сексийн хязгаарлалт, бүжиг, спорт, шашны зан үйл, бэлэг өгөх, зочлох, оршуулах ёс заншил, хэл, боловсрол зэрэг 72 төрлийн нийтлэг шинж байдаг хэмээн тодорхойлсон эрдэмтэн аль нь вэ?

А. Ж.Мёрдок В. У.Самнер С. Э.Тайлор Д. Л.Уайт

33. Английн эрх чөлөөний тулгын чулуу гэж хүлээн зөвшөөрөгддөг бөгөөд шүүхийн шийдвэргүйгээр улсын хуулиас гадуур хүнийг гэм буруутайд тооцож үл болох зарчмыг анхлан тунхагласан баримт бичгийг юу гэж нэрлэдэг вэ?

А.Түгээмэл тунхаглал В.Эрх чөлөөний харти С. Хүний эрхэм чанар Д.Хүний эрхийн суурь зарчим

34. Ажилгүйдлийг бууруулах арга замуудыг өгөгдөлтэй нь зөв харгалзуулна уу?

1	Эдийн засгийн арга	A	Жижиг дунд үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, цалин хөлсийг нэмэх
2	Захиргааны арга	B	Хөдөлмөрийн биржийн албыг бэхжүүлэх, мэргэжил олгох, давтан сургах, хүн амын шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах
3	Гадаад хүчин зүйлсийг ашиглах арга	C	Ажиллах хүч экспортлох, эдийн засгийн чөлөөт бүс байгуулах

A.1A 2 B 3C В. 1B 2 A 3C С. 1C 2 B 3A D. 1A 2 C 3B

35. Төрийн эрх мэдлийг хуваарилах Ш.Монтескьегийн онол аль нь вэ?

А. Хуулийг хэрэгжүүлэх, хууль сахиулах В. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх  
С. Хууль тогтоох, хууль сахиулах, шүүх Д. Хууль тогтоох, шүүх, прокурор

36. Олон улсын харилцаан дахь ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

1	Хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг баталгаажуулах... бодлого баримтлана	A	Эдийн засгийн олон тулгуурт бүтэц
2	Эдийн засгийн судалгаа тооцоонд тулгуурлан, шат дараатай, сонголттойгоор хэрэгжүүлж, олон улсад өрсөлдөх чадвартай бүтцийг бий болгоно	B	Транзит Монгол
3	Үндэсний сонирхлыг тусгасан зорилгуудыг тодорхойлох, бусад улс, олон улсын байгууллагад нөлөөлөх замаар тэдгээр зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа	C	Эдийн засгийн аюулгүй байдал
4	Манай улсын төмөр замын тээвэр нь Ази, Европыг холбосон олон улсын тээврийн коридорын нэг болохын хувьд БНХАУ, ОХУ, Европ болон буцах чиглэлд дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлэх төмөр замын салбарын хөгжилд онцгой ач холбогдолтой	D	Улс төрийн гадаад бодлого

A.1B, 2A, 3C, 4D В.1A, 2C, 3D, 4B С.1B, 2C, 3D, 4A D.1C, 2A, 3B, 4D

37. Цэгийн оронд тохирох өгөгдлийг бичнэ үү? .....иргэд хоорондын эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус амины харилцаанд оролцож, хуулиар олгогдсон эрх эдэлж, үүрэг хүлээж байгаа этгээд юм.

- A. Иргэний эрх зүйн харилцааны оролцогч    B. Иргэний эрх зүйн харилцааны субъект  
C. Иргэний эрх зүйн харилцааны объект    D. Иргэний эрх зүйн харилцааны агуулга

38. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу?

1	Үнэлэмж	A	Нийгмийн бүлэг, хамт олон, бие хүний зан төлөв, үйлдлийг тодорхой шалгуулт нийцэж байна уу үгүй юу гэдгийг шүүн тунгаах үйл явц
2	Үнэлэмжийн баримжаа	B	Үнэлэмжийг хувь хүн өөриймшүүлсэн хэр хэмжээ, түвшин.
3	Үнэлгээ	c	Нийт хүн төрөлхтөний хувьд хүлээн зөвшөөрөгддөг утгат чанарууд

- A. 1A 2B 3AC    B. 1C 2B 3A    C. 1B 2C 3A    D. 1C 2A 3B

39. Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх ямар тохиолдолд үүсэх вэ?

- A. Нийгмийн даатгалын шимтгэлийг 12 сар, түүний сүүлийн 6 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд  
B. Нийгмийн даатгалын шимтгэлийг 24 сар, түүний сүүлийн 12 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд  
C. Нийгмийн даатгалын шимтгэлийг 6 сар, түүний сүүлийн 3 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд  
D. Нийгмийн даатгалын шимтгэлийг тасралтгүй 3 жил төлсөн тохиолдолд

40. Бонд хэмээх ойлголтод хамаарах ойлголт нь:

- A. Банкны зээлийн хүүгээс илүү бага хүү төлдөг  
B. Бонд гаргагч үүргээ биелүүлж чадахгүй бол хөрөнгөө худалдаж өрийн бичиг эзэмшигчийг хохиролгүй болгох үүрэгтэй.  
C. Хугацааны хувьд уян хатан  
D. Дээрх бүгд зөв

**А ХУВИЛБАР ХАРИУ**

<b>Д/Д</b>	<b>ЗӨВ ХАРИУЛТ</b>	<b>ОНОО</b>
<b>1-р хэсэг</b>		
1	A	2
2	C	2
3	B	2
4	D	2
5	B	2
6	D	2
7	D	2
8	C	2
9	D	2
10	B	2
11	B	2
12	C	2
13	A	2
14	D	2
15	A	2
16	E	2
17	B	2
18	D	2
19	A	2
20	D	2
21	D	2
22	A	2
23	C	2
24	D	2
25	C	2
26	B	2
27	A	2
28	B	2
29	D	2
30	A	2
<b>2-р хэсэг</b>		
31	B	4
32	A	4
33	B	4
34	A	4
35	B	4
36	A	4
37	A	4
38	B	4
39	A	4
40	D	4
Нийт оноо		100

## НИЙГЭМ СУДЛАЛ 10-Р АНГИ \ В ХУВИЛБАР \

1. Тухайн байр сууриас үүдэн бий болж, заавал биелүүлэх ёстой, хэм хэмжээлэг шинжтэй зан үйлдлийн цогцыг юу гэж ойлгох вэ?  
A. Нийгмийн статус      B. Нийгмийн үүрэг      C. Нийгмийн элемент      D. Нийгмийн бүтэц
2. Шинэ Гвинейн Чамбули омгийнхны эрчүүд гэртээ сууж, нүүрээ будаж, эмэгтэйчүүдээ тоогдохыг хичээхийг хэвийн гэж үздэг бол манайд ийм эрэгтэйчүүдэд нэр хоч өгч, ад үзэн буруушаадаг. Энэ нь юутай холбоотой вэ?  
A. Гажуудал хувь хүнээсээ хамаараад харьцангуй мөн чанартай байдаг  
B. Гажуудал нийгмээсээ хамаараад харьцангуй мөн чанартай байдаг  
C. Гажуудал соёлоосоо хамаараад харьцангуй мөн чанартай байдаг  
D. Дээрх бүгд зөв
3. “Өөрийнөө санаа бодлыг илэрхийлэхдээ хэрэглэж буй бэлгэ тэмдэг, худалдаа арилжаандаа хэрэглэж буй мөнгөний тогтолцоо, мэргэжлийн зүгээс дагаж мөрдөх горим журам гэх мэт зүйлс надаас, миний хэрэглээнээс үл хамааран оршдог” гэсэн утгыг хэн хэлсэн бэ?  
A. К.Маркс      B. Ж.Г. Мид      C. Э.Дюркгейм      D. Т.Парсонс
4. Хүйс үндэс угсаа зэрэг байр суурь нь:  
A. Төрөлх      B. Олдмол      C. Мастер      D. Үндсэн
5. ....гэдэг нь хувь хүний эдлэх эрх, боломж, гүйцэтгэх үүрэг, бусдын зүгээс хандах хандлагын цогц юм.  
A. Байр суурь      B. Үүрэг      C. Үүргийн зөрчил      D. Нийгмийн бүтэц
6. Бүхий л соёлд нийтлэг байдаг шинж чанар, хэм хэмжээ, дүрэм журам, үнэт зүйлсийг юу гэж нэрлэдэг вэ?  
A. Соёлын хэм хэмжээ      B. Соёлын түгээмэл      C. Соёлын нийтлэг      D. Соёлын нэгдэл
7. Соёл судлал нь ..... зууны эхэн үед бие даасан шинжлэх ухаан болжээ. Тохирох хариуг дугуйлна уу?  
A. XX      B. XIX      C. XXI      D. XYIII
8. Нийт хүн төрөлхтний хувьд хүлээн зөвшөөрөгддөг утгат чанарыг .....гэнэ.  
A. Үнэлэмж      B. Үнэлгээ      C. Үнэлэмжийн баримжаа      D. Үнэт зүйл
9. Хүний эрхийн ойлголт хаана үүссэн бэ?  
A. Итали      B. Грек      C. Ром      D. Франц
10. Соёл бол янз бүрийн бэлгэ тэмдгүүдийн (хэл, бичгийн хэл, урлаг, шинжлэх ухаан гэх мэт) нэгдэл мөн” гэж тодорхойлсон эрдэмтэн аль нь вэ  
A. Гидденс      B. Р. Бенедикт      C. Эдуард Тайлор      D. Эрнст Кассирер
11. 7 хүртэлх насны этгээд эрх зүйн ямар чадамжтай вэ?  
A. Бүрэн чадамжтай      B. Бүрэн бус чадамжтай      C. Заримдаг чадамжтай  
D. Чадамжгүй
12. “ Эрх чөлөөний харти “ хэмээх баримт бичгийг хэдэн онд анхлан гаргасан бэ?  
A. 1205      B. 1225      C. 1215      D. 1235
13. Иргэний эрх зүйн харилцааны бүрдэл хэсгийг нэрлэ.  
A. Субъект      B. Объект      C. Агуулга      D. Дээрхи бүгд
14. Хүний эрхийн түгээмэл тунхаглал хэдэн онд батлагдсан бэ?  
A. 1945 он      B. 1947 он      C. 1948 он      D. 1950 он
15. НҮБ-аас хүний эрхийг хамгаалсан олон гэрээ, конвенцийг батллан гаргасан. Эдгээрээс хамгийн гол баримт бол.....юм.  
A. Хүний эрхийн конвенц      B. Хүүхдийн эрхийн тухай конвенц      C. Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц      D. Хүний эрхийн түгээмэл тунхаглал
16. Монгол улсын хөдөлмөрийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д заасан хөдөлмөрийн гэрээнд заавал тусгах ёстой гол нөхцөл аль нь вэ?

- А.Ажлын байрны буюу албан тушаалын нэр  
 С.Үндсэн цалин буюу албан тушаалын цалингийн хэмжээ  
 В.Хөдөлмөрийн нөхцөл  
 D.Ажлын байрны тодорхойлолтод заасан ажил, үүрэг
17. ААН-ийн эздийн орлого нь:  
 А. Цалин В. Зээлийн хүү С. Түрээсийн төлбөр D. Ашиг
18. Ажилгүйдэл 1 % өсөхөд үйлдвэрлэлийн хэмжээ 2.5% буурдаг болохыг баталсан эрдэмтэн нь хэн бэ?  
 А. Оукен В. Лоренц С. Дуо Джонсон D. А. Лаффер
19. Инфляцийн төрөлд хамаарахгүй ойлголтыг олно уу?  
 А.Мөлхөө инфляци В.Өсөх инфляци С.Цогио инфляци D.Гипер инфляци
20. ДНБ-ийг орлогоор тооцох аргыг тодорхойлохдоо илүүц зүйл оруулсан бол аль нь вэ?  
 А.Цалингийн орлого В.Төрийн зардал С.ААН-ийн ашиг D.Түрээсийн орлого
21. Эдийн засгийн уналттай холбоотой үүсэн ажилгүйдлийн хэлбэрийг .....гэнэ.  
 А.Байнгын ажилгүйдэл В. Мөчлөгийн ажилгүйдэл С.Улирлын ажилгүйдэл D.Шилжилтийн ажилгүйдэл
22. Үлээх, “хөөрөгдөх” гэсэн утгатай латин гаралтай үг бөгөөд эдийн засагт бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ ерөнхийдөө өсөж хүн амын худалдан авах чадвар буурах үзэгдлийг юу гэж нэрлэдэг вэ?  
 А.Дефляци В.Инфляци С. Үнийн өсөлт D. Хэрэглээний сагс
23. Олон улсын хүний эрхийн өдөр хэзээ болдог вэ?  
 А. 12 сарын 08 В. 12 сарын 10 С. 12 сарын 29 D. 1 сарын 22
24. БНМАУ-ын төрийн байгууллыг хөгжүүлэн бэхжүүлэх зорилгоор хөдөлмөрчдийн эрх ашигт нийцүүлэн БНМАУ-ын иргэдэд үг хэлэх, хэвлэн нийтлэх, хурал цуглаан хийх, жагсаал ёслол үйлдэх эрх чөлөөг хуулиар батлан олгосон нь аль үндсэн хуулийн талаар мэдээлж байна вэ?  
 А. 1924 он В. 1940 он С. 1960 D. 1992
25. Монгол улсын “Шинэ үндсэн хууль” хэдэн онд батлагдсан бэ?  
 А.1924.11.26 В.1940.06.30 С. 1960.11.30 D.1992.01.13
26. Ардчиллын үнэт зүйлсийг нарийвчлан судалж, ойлголтыг цэгцэлж өгсөн эрдэмтэн хэн бэ?  
 А.Р.Даль В.Д.Истон С.Г.Алмонд D.Макиавелли
27. НҮБ-ын аюулгүйн зөвлөлд 15-н гишүүн байдгаас 5 нь байнгын гишүүн орон байдаг. Зөв өгөгдлийг олно уу.  
 А. Япон, Итали, Франц, Англи, Орос В. Турк, Итали, Франц, Англи, Орос  
 С. Солонгос, Монгол, Орос, Канад, Австри D. Их Британи, Америк, Орос, Франц, Хятад
28. Монгол улс 1961 он хүртэл олон улсын хүрээнд бүрэн тусгаар улс шиг байж чадахгүй, хүлээн зөвшөөрлийг нь итгэл хүлээлгэхгүй байгаад байсан нь улс оролцогчийн ямар хэлбэрийн талаар мэдээлж байна вэ?  
 А. De Jure В. Ad Hoc С. De Facto D. De integro
29. Өөрийн ойрын хүрээлэлдээ ялангуяа хөрш улсууд, бүс нутагтаа баттай нөлөөлдөг, голчлон тогтвортой эдийн засгийн хөгжилтэй улсуудыг ямар улсын ангилалд багтах вэ?  
 А. Их гүрэн В. Дунд улс С. Бага улс D. Буурай улс
30. Монгол улс хоёр хөрштэйгээ харилцах зарчмуудыг нэрлэхдээ илүүц зүйл оруулсан бол аль нь вэ?  
 А.Улс төрийн В. Стратегийн түншлэлийн С. Сайн хөршийн D.Олон тулгуурт
31. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу?

1	Хувьсагч	А	Бусад хувьсагчийн нөлөөгөөр өөрчлөгдөж буй хувьсагч
---	----------	---	---

1	Үл хамаарах хувьсагч	В	Бусад хувьсагчийн өөрчлөлтөд нөлөөлж буй, шалтгаан нь болж буй хувьсагч
2	Хувьсагч	С	Хоёр ба түүнээс дээш утга, шинжээр илэрч байдаг зүйл
3	Хамаарах хувьсагч		

A. 1c2b3a      B. 1c2a3b      C. 1a2b3c      D. 1b,2c,3a

32. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу?

1	Бэлгэ тэмдэг	A	Хүмүүсийн мэддэг баримт, туршлага, үнэт зүйлсийг хэлнэ.
2	Хэл	B	Хүмүүсийн зан төлвийг зохицуулдаг дэг журам, хууль дүрэм, ёс заншил зэргийг бүхэлд нь хэлнэ.
3	Үнэлэмж	C	Юуг зөв гэж хүлээн зөвшөөрөх, бас юуг буруу, зохисгүй гэж үзэх талаар нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн эрхэм чанаруудыг хэлнэ.
4	Хэм хэмжээ	D	Хүний оюуны ертөнцийг илэрхийлэгч, хадгалагч, дамжуулагч арга хэрэгсэл.
5	Мэдлэг	E	Соёл бол хүн бодол санаагаа ямар нэг тэмдэгтэд төлөөлөл, бэлгэдэл болгон шингээж буй хэрэг юм.

A. 1D2E3C4A5B      B. 1C2A3D4B5E      C. 1E2D3C4B5A      D. 1A2D3C4B5E

33. Арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улстөрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, өмч хөрөнгө, төрсөн байдал болон нийгэмд эзэлж байгаа байр сууриас үл хамааран хэнийг ч ялгаварлан гадуурхаж болохгүй. Хүний эрхийн суурь зарчмын аль нь вэ?

A. Хуваагдашгүй байх      B. Харилцан хамааралтай байх      C. Ялгаварлан гадуурхал байх      D. Түгээмэл, салшгүй байх

34. М>р᠒ томъёоллын үед эдийн засагт аль нөхцөл үүсэх вэ?

A. Эдийн засагт мөнгөний илүүдэл бий болж, мөнгө үнэ цэнээ алдаж, улмаар инфляци үүснэ.

B. Мөнгөний хомсдол бий болж нийт эрэлт буурна.

C. Мөнгөний тоо үйлдвэрлэсэн бараа үйлчилгээ тэнцэж, эдийн засаг тогтвортой байна.

D. B ба C нөхцөл үүснэ.

35. Ардчилалын зарчмуудыг зөв харгалзуулна уу?

1	Иргэдийн зүгээс улс төрчид, төрийн албан хаагчдад хяналт тавих, тэдний үйл ажиллагааг сайжруулах, авилга, хээл хахуульд өртөхөөс урьдчилан сэргийлэх орчныг бүрдүүлдэг	A	Хууль дээдлэх зарчим
2	Иргэдэд адил тэнцүү боломж олгодог ба энэ нь хэн нэгнийг илүү харж, эрх дарх олгохгүй гэсэн үг юм	B	Цөөнхийг хүндэтгэх зарчим
3	Нийгэмд хүн бүр хуулийн хүрээнд ажиллаж амьдрах үүрэгтэй.	C	Зөвшилцлийн зарчим
4	Олонх нь удирдан захирч цөөнхийг эрхийг хуулиар болон хуулийн байгууллагаар дамжуулан хамгаалдаг	D	Нээлттэй зарчим
5	Улс төрийн намууд, бүлгүүдийн хооронд үзэл бодол, байр суурийн ялгааг нэгтгэх арга зам	E	Шударга байх зарчим

A. 1C, 2D, 3A, 4B, 5E      B. 1D 2E, 3C, 4A, 5B      C. 1A 2B, 3E, 4D, 5C      D. 1E, 2D, 3A, 4B, 5C

36. Зөв харгалзуулна уу.

1	Зан үйлийг хянах, зохицуулах	A	Гэр бүл
2	Нийгмийн нэгдэл, нягтралыг хангах, дээд ариун нандин зүйлд итгэх	B	Төр засаг, хууль, шүүх, цагдаа, шашин
3	Хэрэгцээт бараа үйлчилгээгээр хангах	C	Шашин боловсрол
4	Нийгмийн шинэ гишүүнийг төрүүлэх	D	Эдийн засаг

A. 1C, 2B, 3D, 4A      B. 1C, 2B, 3A, 4D      C. 1B, 2C, 3A, 4D      D. 1B, 2A, 3C, 4D

37. Хувьцааны давуу талуудыг нэрлэхдээ илүүц зүйл оруулсан бол аль нь вэ?



А.Ногдол ашиг авах      В. Ханшийн зөрүүнээс ашиг олох      С.Хувьцаа хөрвөх чадвартай      D. Хувьцааны ханш унаж болно

38. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу?

1	Тогтоол	A	Үндсэн хуулийн цэц, Аймаг, нийслэлийн ИТХ
2	Зарлиг	B	Аймаг нийслэлийн засаг дарга
3	Тушаал	C	Сайд, засгийн газрын агентлагын дарга
4	Захирамж	D	Ерөнхийлөгч
5	Шийдвэр	E	Улсын Их Хурал, Засгийн газар, Улсын дээд шүүх

A. 1a2d3c4b5e      B. 1e2d3c4b5a      C. 1e2c3d4b5a      D. 1e2d3c4a5b

39. Төрийн эрх мэдлийг хуваарилах Ш.Монтескьегийн онол аль нь вэ?

A. Хуулийг хэрэгжүүлэх, хууль сахиулах      B. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх

C. Хууль тогтоох, хууль сахиулах, шүүх      D. Хууль тогтоох, шүүх, прокурор

40. Монгол улсын олон улсын хамтын нийгэмлэг дэх оролцооны зарчим, тэдгээрийн агуулгуудыг зөв харгалзуулна уу?

1	Олон тулгуурт байх	A	Энэ зарчим нь үндэсний язгуур ашиг сонирхлыг сахин хамгаалсан, үндэсний хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйлчилнэ
2	Прагматик байх	B	Монгол улсын хувьд стратегийн ач холбогдол бүхий гүрнүүдийн Монгол дахь эдийн засгийн болон бусад сонирхлыг тэнцвэржүүлэхэд чиглэнэ.
3	Тэнцвэртэй байх	C	Энэ зарчим нь гадаад харилцаа, хамтын ажиллагаандаа нөөц бололцоог аль болох бүрэн дайчлан зохион байгуулах явдал юм.
4	Үндэсний эрх ашигт нийцсэн байх	D	Аль болох олон улс оронтой хамтран ажиллах, нөгөө талаас гадаад харилцааг аль болох олон хэлбэрээр явуулахад оршино

A. 1d2a3b4c      B. 1d2c3a4b      C. 1d2c3b4a      D. 1c2d3b4a

**В ХУВИЛБАР ХАРИУ**

<b>Д/Д</b>	<b>ЗӨВ ХАРИУЛТ</b>	<b>ОНОО</b>
<b>1-р хэсэг</b>		
1	В	2
2	В	2
3	С	2
4	А	2
5	А	2
6	В	2
7	А	2
8	А	2
9	В	2
10	Д	2
11	Д	2
12	С	2
13	Д	2
14	С	2
15	В	2
16	Д	2
17	Д	2
18	А	2
19	В	2
20	В	2
21	В	2
22	В	2
23	В	2
24	С	2
25	Д	2
26	А	2
27	Е	2
28	А	2
29	В	2
30	А	2
<b>2-р хэсэг</b>		
31	А	4
32	С	4
33	С	4
34	А	4
35	Д	4
36	А	4
37	Д	4
38	В	4
39	В	4
40	С	4
Нийт оноо		100

### НИЙГЭМ СУДЛАЛ 10-Р АНГИ \С ХУВИЛБАР \

1. Нийгмийн бүтэц гэдэг нь нийгмийн хэсэг, элементүүдийн хооронд бэхжсэн тогтвортой харилцаа холбоог хэлнэ гэж хэн хэлсэн бэ?  
A. А.Гидденс    В. Р.Бенедикт    С. В.Занден    D. Э.Кассирер
2. Нийгэмшилтэд нөлөөлж буй хувь хүн, бүлэг, байгууллага, нийгмийн тодорхой нөхцөлүүдийн цогцыг юу гэж нэрлэдэг вэ?  
A. Нийгэмшлийн агент    В. Нийгэмшилт    С. Харилцан үйлдэл    D. Нийгмийн зөрчил
3. Ажил эрхлэлт нь боловсролын түвшнээс хамаарч байгаа гэж үзвэл үл хамаарах хувьсагч аль нь вэ?  
A. Ажил эрхлэлт    В. Ажил мэргэжил    С. Боловсрол    D. А,С хувилбар
4. Цэгийн оронд тохирох өгөгдлийг дугуйлна уу.  
..... гэдэг нь хоёр ба түүнээс дээш тооны хүмүүс харилцан бие биенийхээ үйлдэлд бэлгэ тэмдгийг ашиглах замаар хариу өгч буй үйл явцыг хэлнэ.  
A. Нийгмийн харилцаа    В. Харилцан үйлдэл    С. Нийгэм    D. Нийгмийн үүрэг
5. Нийгэм болон нийгмийн хэсэг бүлгийн оюун санаа, материаллаг байдал, мэдлэг, оюун сэтгэл санааны шинж байдлын цогцыг юу гэж нэрлэдэг вэ?  
A. Соёл    В. Соёлын олон янз байдал    С. Зонхилогч соёл    D. Дэд соёл
6. Соёл бол янз бүрийн бэлгэ тэмдгүүдийн нэгдэл мөн гэж хэн хэлсэн бэ?  
A. А.Гидденс    В. Р.Бенедикт    С. Э.Тайлор    D. Э.Кассирер
7. Соёл нь нийтлэг итгэл үнэмшил, үнэлэмжийн тогтолцоог бүрдүүлэх замаар нийгмийг нэгтгэдэг. Энэ нь соёлын чиг үүргүүдийн алинд нь хамаарах вэ?  
A. Бэлгэдлийн чиг үүрэг    В. Нэгтгэн, зохицуулах чиг үүрэг    С. Үнэлэмж, хэм хэмжээний чиг үүрэг    D. Үйл ажиллагааны чиг үүрэг
8. Дэд соёлыг зөв тодорхойлсон тодорхойлолтыг сонгоно уу.  
A. Тухайн нийгмийн гишүүдийн дийлэнх нь зонхилж буй амьдрах зан үйл, үйлдлийн загварыг тодорхойлогч соёл  
B. Ойлголтоороо тухайн улс үндэсний нийтийн хүртээл болсон итгэл үнэмшил, зан байдлын хэв маяг, үнэлэмжийн нэгдлийг илэрхийлдэг.  
C. Зохилогч соёлоос бага зэргийн ялгаатай боловч түүнтэй нийцэж байдаг соёл  
D. нийгмийн бүлэг, хамт олон, бие хүний зан төлөв, үйлдлийн тодорхой шалгуурт нийцэж байна уу, үгүй юу гэдгийг шүүн тунгаах үйл явц
9. НҮБ хэдэн онд байгуулагдсан бэ?  
A. 1961    В. 1945    С. 1989    D. 1939
10. Хүн болж төрснийхөө хувьд хүн бүр ижил үнэ цэнтэй байж, адил хүндэтгэлийг эдэлэх нь хүний эрхийн зарчмуудын алинд хамаарах вэ?  
A. Тэгш байдлыг хангах    В. Түгээмэл, салшгүй байх    С. Хуваагдашгүй байх    D. Харилцан хамааралтай байх
11. Rule of law үгийн утгыг зөв тайлбарласан хэсгийг сонгоно уу.  
A. Хуульд захирагдах ёс    В. Ёс зүйд захирагдах ёс    С. Эрх зүйд захирагдах ёс    D. Ёс суртахуунд захирагдах ёс
12. Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор захиргааны байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг ..... гэнэ.  
A. Тогтоол    В. Захиргааны акт    С. Захирамж    D. Тушаал
13. Эдийн баялаг болон эд юмс, эдийн бус баялаг болох оюуны үнэт зүйлсийг иргэний эрх зүйн харилцаанд юу гэж нэрлэдэг вэ?  
A. Иргэний эрх зүйн харилцааны агуулга    В. Иргэний эрх зүйн харилцааны субъект    С. Иргэний эрх зүйн харилцааны объект    D. Иргэний эрх зүйн харилцаа
14. Нийгмийн хамгааллын эрх зүйн харилцаа нь хэдэн төрөлтэй байдаг вэ?  
A. 2    В. 3    С. 4    D. 5
15. Тухайн улсын хэмжээгээр нэг жилийн хугацаанд үйлдвэрлэсэн, эцсийн бараа, үйлчилгээний зах зээлийн үнийн дүнг юу гэж нэрлэдэг вэ?

- A. ДНБ      В. Нэрлэсэн ДНБ      С. Бодит ДНБ      D. Нэг хүнд ногдох ДНБ
16. Ямар нэг компанийн өмчийн тодорхой хэсгийг эзэмшиж буйг гэрчилсэн баримтыг юу гэж нэрлэдэг вэ?  
A. Бонд      В. Хувьцаа      С. Зээл      D. Хадгаламж
17. угар барилга дээр ажилладаг ч өвлийн улиралд ажил нь түр хугацаагаар зогссон тул одоо ажилгүй байна. Энэ нь ажилгүйдлийн аль төрөлд хамаарах вэ?  
A. Мөчлөгийн      В. Шилжилтийн      С. Бүтцийн      D. Улирлын
18. Зөв хариултыг дугуйлна уу.

.....нь тоон үзүүлэлт, тэдгээрийн харьцааг шугам, геометрийн дүрс, зураг эсвэл газар зүйн картын тусламжтайгаар илэрхийлэх арга юм.


- A. Шугаман диаграмм      В. Баганан диаграмм      С. График      D. Диаграмм
19. Өсөлтийн хурдыг тухайн оны түвшинг өмнөх оны түвшинд харьцуулж 100 хувиар үржүүлж 100 хувийг хасаж тооцно. Энэ нь үзүүлэлтийн цэвэр өсөлтийн хувиар илэрхийлдэг өсөлтийг юу гэж нэрлэдэг вэ?  
A. Абсолют цэвэр өсөлт      В. Өсөлтийн хурд      С. Цогио өсөлтийн хурд  
D. Цэвэр өсөлтийн хурд
20. Ардчилал нь ард түмнээс сонгогдсон, ард түмний төлөө, ард түмний өөрсдийнх нь засаглал юм гэж хэн хэлсэн бэ?  
A. А.Линколын      В. Д.Истон      С. Ш.Монтескье      D. Ж.Локк
21. Demos гэж ямар утгатай үг вэ?  
A. Засаглал      В. Ардчилал      С. Ард түмэн      D. Ардчилсан засаглал
22. Иргэд нь улс төрийн шийдвэр гаргах, хууль боловсруулах үүрэг бүхий албан тушаалтныг сонгож, түүгээр дамжуулан засаглалыг хэрэгжүүлэх хэлбэр аль нь вэ?  
A. Шууд ардчилал      В. Төлөөллийн ардчилал      С. Ард түмний засаглал  
D. Нээлттэй ардчилал
23. Ардчилсан нийгэм бүх иргэдэд адил тэнцүү боломж олгодог онцлогтой. Энэ нь хэн нэгнийг илүү харж, эрх дарх олгохгүй гэсэн үг юм. Энэ нь ардчиллын аль зарчимд хамаарах вэ?  
A. Нээлттэй зарчим      В.Шударга байх зарчим      С. Хууль дээдлэх зарчим  
D. Цөөнхийг хүндэтгэх зарчим
24. Монгол улс үндсэн хуулиа хэдэн удаа шинэчлэн баталсан бэ?  
A. 2      В. 3      С.4      D.5
25. Манай улсад хууль тогтоох эрх мэдлийг ямар байгууллага хэрэгжүүлдэг вэ?  
A. Ерөнхийлөгч      В.Шүүх      С. Ард түмэн      D. УИХ
26. МоАХ-ны анхны цуглаан хэзээ болсон бэ?  
A. 1989.12.01      В. 1989.12.20      С. 1989.12.10      D. 1989.12.29
27. Төрийн эрх барих дээд байгууллага аль нь вэ?  
A. УИХ      В.Ерөнхийлөгч      С. Засгийн газар      D. Шүүх
28. НҮБ-ын энхийг сахиулах үйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний VI ээлжийн мотобуудлагын батальоны бие бүрэлдэхүүнийг ямар медалиар шагнасан бэ?  
A. Сайн үйлстэн      В. Энхийг сахиулагч      С.Энхийн төлөө      D. Энхийн үйлстэн
29. Олон улсын харилцаанд нөлөө багатай ч өөрийн тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэрэгсэлтэй байдаг нь олон улсын харилцааны аль улс оролцогчийн шинж вэ?  
A. Их гүрэн      В.Бага улс      С.Дунд улс      D. Улс бус оролцогч
30. Тухайн улс үндэстэнтэй шууд хил залгаа оршдог, тэр улсын дотоод, гадаад бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход үлэмж нөлөө үзүүлдэг улс орнуудыг юу гэж нэрлэдэг вэ?

- A. Их гүрэн                      В.Бага улс                      С.Дунд улс                      D. Хөрш улс
31. Монгол улс хэдэн онд НҮБ-ын гишүүнээр элссэн бэ?  
A. 1945                      В. 1948                      с. 1961                      D.1989
32. Олон улсын харилцаанд иргэд хоорондын харилцааг хэрхэн зохицуулдаг вэ?  
A. Олон улсын шүүх                      В. Иргэний эрх зүй                      С. Ёс зүйн хэм хэмжээ                      D. Эрх зүй
33. Эрх гэрийн хэрэглээний зардлыг ямар үсгээр тэмдэглэдэг вэ?  
A. X                      В. I                      C.G                      D.C
34. Соёлыг бүрдүүлэгч элементүүдээс дутуу бичигдсэн өгөгдлийг дугуйлна уу.



- A. Ёс заншил  
B. Тэмдэг  
C. Ёс зүй  
D. Үнэлэмж

